



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Журам, загвар батлах тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.5, 10.8-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Хяналтын улсын байцаагчийн үнэмлэхийн загвар”-ыг 2 дугаар хавсралт, “Хяналтын улсын байцаагчийн тэмдгийн загвар”-ыг 3 дугаар хавсралт, “Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг олгох, хэрэглэх, түүнд хяналт тавих журам”-ыг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Энэ тогтоолын 1-д заасан журмыг хэрэгжүүлж, хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор хэвлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд тус тус даалгасугай.

3.Мэргэжлийн хяналтын чиг үүрэг салбарын яамдад шилжсэнтэй холбогдуулан “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын 3 дахь заалтын “46” гэснийг “53” гэж, “42” гэснийг “51” гэж, “34” гэснийг “37” гэж тус тус өөрчилсүгэй.

4.Энэ тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД


Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

ШТА0609 9023010224 5498449

Засгийн газрын 2023 оны 01 дүгээр
сарын 01-ний өдрийн 06 дугаар
тогтоолын 01 дүгээр хавсралт



ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ЭРХ ОЛГОХ, ЦУЦЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч (цаашид хамтад нь “хяналтын улсын байцаагч” гэх) хуулиар эрх олгосон байгууллагын болон хяналт шалгалтын чиг үүргийг шилжүүлж авсан албан тушаалтанд эрх олгох, цуцлахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмыг баримтална.

1.2.Хяналтын улсын байцаагчийн эрхийг эрхлэх асуудлынх нь хүрээнд тухайн салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарч байгаа Засгийн газрын гишүүн олгоно.

1.3.Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга болон стандарт, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргад тус тус салбарын улсын ерөнхий байцаагчийн эрхийг олгоно.

1.4.Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын бүтцийн нэгжийн хяналт шалгалт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан хаагч, стандарт, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга, хуульд заасан бол хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны бусад байгууллагын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга, хуулиар эрх олгосон байгууллагын болон хяналт шалгалтын чиг үүргийг шилжүүлж авсан албан тушаалтанд болон орон нутаг дахь хяналт шалгалтын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжийн даргад тус тус улсын ахлах байцаагчийн эрхийг олгоно.

1.5.Шаардлагатай тохиолдолд нутаг дэвсгэрийн онцлогоос шалтгаалан улсын ахлах байцаагчийн эрхийг энэ журмын 1.4-т зааснаас бусад орон нутагт ажиллаж байгаа улсын байцаагчид олгож болно.

1.6.Орон нутаг дахь хяналт шалгалтын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжийн хяналт шалгалт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан хаагч, хуулиар эрх олгосон байгууллагын болон хяналт шалгалтын чиг үүргийг шилжүүлж авсан албан тушаалтанд улсын байцаагчийн эрхийг олгоно.

Хоёр.Хяналтын улсын байцаагчийн эрх
олгоход тавигдах шаардлага

2.1.Хяналтын улсын байцаагчийн эрх авах албан хаагчид дараахь шаардлага тавигдана:

2.1.1.Төрийн албаны тухай хуулийн 22, 23 дугаар зүйлд заасан төрийн албан тушаалд тавигдах нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан байх;

2.1.2.тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжлийн шаардлага хангасан байх;

2.1.3.хуулиар тогтоосон улсын байцаагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлж чадах мэдлэг, туршлага, мэргэжлийн ур чадвартай байх;

Гурав.Хяналтын улсын байцаагчийн эрх олгоход
бүрдүүлэх баримт бичиг

3.1.Хяналтын улсын байцаагчийн эрх олгоход дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

3.1.1.төрийн албан хаагчийн анкет (Маягт №1);

3.1.2.энэ журмын 2.1.1-2.1.3-т заасан шаардлагыг хангаж байгааг нотлох баримт.

3.2.Энэ журмын 4.1-д заасан албан тушаалтан хяналтын улсын байцаагчийн эрх олгох албан хаагчийн мөн журмын 3.1-д заасан баримт бичгийг хүсэлтийн хамт салбарын улсын ерөнхий байцаагчид хүргүүлнэ.

Дөрөв.Хяналтын улсын байцаагчийн эрх олгох

4.1.Хяналтын улсын байцаагчийн эрх олгуулах хүсэлтийг тухайн албан хаагчийг томилох эрх бүхий албан тушаалтан гаргана.

4.2.Улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрх олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан Засгийн газрын гишүүн салбарын улсын ерөнхий байцаагчийн саналыг харгалзан гаргана.

4.3.Салбарын улсын ерөнхий байцаагч энэ журмын 3.1-д заасан баримт бичгийг нягтлан шалгаад тухайн улсын байцаагчийн эрхийг олгох эсэх саналаа мөн журмын 4.2-т заасан Засгийн газрын гишүүнд танилцуулна.

4.4.Хяналтын улсын байцаагчийн эрх авсан салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагчид албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг олгоно.

Тав.Хяналтын улсын байцаагчийн эрхийг цуцлах

5.1.Дараахь тохиолдолд хяналтын улсын байцаагчийн эрхийг тухайн салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарч байгаа Засгийн газрын гишүүн цуцална:

5.1.1.хяналтын улсын байцаагч өөр ажил, албан тушаалд томилогдсон, сонгогдсон;

5.1.2.хяналтын улсын байцаагч төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, чөлөөлөгдсөн, халагдсан;

5.1.3.хяналтын улсын байцаагч нас барсан;

5.1.4.Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж зөрчсөн;

5.1.5.төрийн албан хаагчийн болон улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээг ноцтой буюу удаа дараа зөрчсөн, мэргэжлийн алдаа гаргасан;

5.1.6.гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

5.1.7.хуульд заасан бусад.

5.2.Хяналтын улсын байцаагчийн эрхийг цуцалсан тохиолдолд тухайн улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийг хураан авна.

Зургаа.Бусад зүйл

6.1.Энэ журмын хяналтын улсын байцаагчийн эрх олгохтой холбогдсон зохицуулалт 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө хяналтын улсын байцаагчийн эрх авсан улсын ахлах байцаагч, улсын байцаагчид хамаарахгүй.

6.2.Энэ журмыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш шинээр хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлахад баримтална.

----oOo----

Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 04 -ний өдрийн 06 дугаар тогтоолын 02 дугаар хавсралт

ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ҮНЭМЛЭХИЙН ЗАГВАР

Байгууллагын
бэлгэдэл /Байгууллагын нэр/

Зураг /3x4/

Дугаар ...
.....
/Хяналтын улсын байцаагчийн хяналтын чиглэл/

Эцэг /эх/-ийн нэр:
Өөрийн нэр:

**ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ
ОБЪЕКТОД СААДГҮЙ НЭВТРЭХ
ЭРХТЭЙ.**

Дугаар ...

Монгол Улсын хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд хяналт тавьж, хуульд заасан арга хэмжээ авч, хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтан тул үнэмлэх олгов. The identification card (ID) is issued to authorized state officer to inspect compliance and implementation of laws, regulations and standards of Mongolia, and to take measure and sanctions in obedience to the respective law.

Олгосон он, сар, өдөр:

САЙД
Гарын үсэг /Гарын үсгийн тайлал/

Үнэмлэхийг зориулалт бусаар ашиглах, бусдад шилжүүлэх, барьцаалахыг хориглоно.

Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх босоо хэлбэртэй, 2 нүүр байна.


Салбарын улсын ерөнхий байцаагчийн үнэмлэх улаан өнгийн, улсын ахлах байцаагчийн үнэмлэх хөх өнгийн, улсын байцаагчийн үнэмлэх ногоон өнгийн хавтастай байна.

Хяналтын улсын байцаагчийн үнэмлэхийн хавтасны гадна талд тухайн салбарыг илэрхийлсэн бэлгэдэл (лого)-тэй байж болно.

Хяналтын улсын байцаагчийн үнэмлэхийн хавтасны нүүрэн талд “Салбарын улсын ерөнхий байцаагч”, “Улсын ахлах байцаагч”, “Улсын байцаагч” гэсэн үгийг алтан шармалаар кирилл үсгээр голлуулан бичнэ.

Хяналтын улсын байцаагчийн үнэмлэхийн суурь нь цэнхэр тэнгэрийн өнгө, үргэлжилсэн хас хээ байх бөгөөд хяналтын чиглэл, байгууллагын нэртэй хэсэг хөх өнгийн дэвсгэртэй байна.

Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 06 дугаар тогтоолын 03 дугаар хавсралт



ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ТЭМДГИЙН ЗАГВАР

1.Салбарын улсын ерөнхий байцаагчийн тэмдгийн загвар:



1.1.Салбарын улсын ерөнхий байцаагчийн тэмдгийн дардасны хэсгийг резинээр хийх бөгөөд тэмдэг нь 35х35 мм-ийн дөрвөлжин хэлбэртэй байна.

1.2.Тэмдгийн үсэг нь кирилл үсгээр бичигдсэн байна.

1.3.Салбарын улсын ерөнхий байцаагчийн тэмдгийн голд "...-ын САЛБАРЫН УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ" гэсэн үг, дээд хэсэгт байгууллагын бэлгэдэл, доод хэсэгт албаны болон хувийн дугаар байна.

1.4.Тэмдгийн дөрвөн өнцөгт загасан нүд, гадна хүрээ төв хэсгийн хүрээ алхан хээгээр хүрээлэгдэнэ.

2.Улсын ахлах байцаагчийн тэмдгийн загвар:



2.1.Улсын ахлах байцаагчийн тэмдгийн дардасны хэсгийг резинээр хийх бөгөөд тэмдэг нь 35х35 мм-ийн 16 талт дугуй хэлбэртэй байна.

2.2.Тэмдгийн үсэг нь кирилл үсгээр бичигдсэн байна.

2.3.Улсын ахлах байцаагчийн тэмдгийн хүрээг дагаж байгууллагын нэр болон “УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ” гэсэн үгийг том үсгээр бичиж, дээд хэсэгт байгууллагын бэлгэдэл, доод талд улсын ахлах байцаагчийн хувийн дугаар, загасан нүд байна.

3.Улсын байцаагчийн тэмдгийн загвар:




3.1.Улсын байцаагчийн тэмдгийн дардасны хэсгийг резинээр хийх бөгөөд тэмдэг нь 35х35 мм-ийн 32 тал бүхий дугуй хэлбэртэй байна.

3.2.Тэмдгийн үсэг нь кирилл үсгээр бичигдсэн байна.

3.3.Улсын байцаагчийн тэмдгийн хүрээг дагаж дагаж байгууллагын нэр болон “УЛСЫН БАЙЦААГЧ” гэсэн үгийг том үсгээр бичиж, дээд хэсэгт байгууллагын бэлгэдэл, доод талд улсын байцаагчийн хувийн дугаар, загасан нүд байна.

----oOo----

Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 06 дугаар тогтоолын 04 дүгээр хавсралт



ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ҮНЭМЛЭХ, ТЭМДЭГ ОЛГОХ, ХЭРЭГЛЭХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч (цаашид “хяналтын улсын байцаагч” гэх)-ийн үнэмлэх, тэмдэг олгох, хэрэглэх, хяналт тавихад энэ журмыг баримтална.

1.2.Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг нь албаны болон хувийн дугаараас бүрдсэн дугаартай байна.

1.3.Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг дэх албаны дугаарын эхний 2 оронтой тоо нь энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагын, эсхүл төрийн захиргааны байгууллагын код, дараагийн 2 оронтой тоо нь аймаг, нийслэлийн код байх бөгөөд сүүлийн 5 оронтой тоо нь салбарын хяналтын чиглэл болон хувийн дугаар байна.

1.4.Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын бүтцийн нэгжийн хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийн дугаарын хяналт шалгалтын чиг үүрэг хэрэгжүүлэх орон нутаг дахь нэгжийн код 00 байна. (Жишээ нь: Стандарт, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын бүтцийн нэгжийн хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийн дугаар “02-00-01/001”)

1.5.Хяналт шалгалтын чиг үүрэг хэрэгжүүлэх орон нутаг дахь нэгжийн улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийн дугаар нь хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагын кодоор эхэлнэ. (Жишээ нь: Архангай аймгийн хяналт шалгалтын чиг үүрэг бүхий нэгжийн улсын байцаагч “01-13-01/001”)

1.6.Хяналтын улсын байцаагчийн үнэмлэхийн болон тэмдгийн дугаар ижил байна.

1.7.Хяналтын улсын байцаагчийн хувийн дугаарыг давхардуулж олгохгүй.

1.8.Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг нууцлалтай байна.

1.9.Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг олгох, хэрэглэх, хяналт тавихтай

холбогдсон асуудлыг тухайлсан нэг ажилтан (цаашид “хариуцсан ажилтан” гэх)-д хариуцуулна.

1.10.Хариуцсан ажилтан хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийн бүртгэлийг энэ журмын 2 дугаар хавсралтад заасан хүснэгтийн дагуу хөтөлнө.

1.11.Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийг анхны удаад үнэ төлбөргүй олгох бөгөөд хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг нь тухайн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын өмч байна.

1.12.Төрийн захиргааны төв байгууллага нь хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийн дардасны судалгааг улирал тутамд авч, хяналт тавина.

Хоёр.Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх,
тэмдэг олгох

2.1.Хяналтын улсын байцаагчийн эрх авсан албан хаагчид улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийг тухайн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага олгоно.

Гурав.Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх,
тэмдэг хэрэглэх

3.1.Хяналтын улсын байцаагч хууль тогтоомжоор тогтоосон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улсын байцаагчийн үнэмлэх хэрэглэнэ.

3.2.Хяналтын улсын байцаагч Засгийн газраас баталсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-ын 19.1-д заасан хяналт шалгалтын баримт бичгийг үйлдэхэд тэмдэг хэрэглэнэ.

3.3.Хяналтын улсын байцаагч энэ журмын 3.1, 3.2-т заасан үнэмлэх, тэмдгийн хадгалалт, хамгаалалтыг хариуцна.

3.4.Хяналтын улсын байцаагч улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгээ бусдад шилжүүлэх, ашиглуулах, барьцаалах, үрэгдүүлэх, гэмтээх, хууль бусаар хийлгэх, хэлбэр, загварыг өөрчлөх, хувилах, өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.

3.5.Хяналтын улсын байцаагч улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгээ хаясан, үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болгосон бол энэ тухайгаа дээд шатны улсын байцаагчид нэн даруй мэдэгдэж, өдөр тутмын сонинд зарлуулна.

Дөрөв.Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийн хэрэглээ,
хадгалалтын байдалд хяналт тавих

4.1.Салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч нь улсын байцаагч үнэмлэх, тэмдгээ хэрэглэж байгаа болон хадгалалтын байдалд хяналт тавина.

Тав.Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг
дахин болон сольж олгох

5.1.Хяналтын улсын байцаагч үнэмлэх, тэмдгээ хаясан, үрэгдүүлсэн бол тухайн үнэмлэх, тэмдгийн дугаарыг тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр хүчингүй болгож, шинэ дугаар олгоно.

5.2.Энэ журмын 5.1-д заасны дагуу хүчингүй болгосон үнэмлэх, тэмдгийн дугаарыг дахин олгох, шилжүүлэн хэрэглүүлэхийг хориглоно.

5.3.Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийг хэрэглэх боломжгүйгээр гэмтээсэн бол дугаарыг өөрчлөхгүйгээр сольж олгоно.

5.4.Энэ журмын 5.1, 5.3-т заасан тохиолдолд хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийн үнийг тухайн улсын байцаагчаар төлүүлнэ. Энэ нь энэ журмын 6.4-т заасан сахилгын шийтгэлээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Зургаа.Бусад зүйл

6.1.Хяналтын улсын байцаагчийн эрх нь цуцлагдсан тохиолдолд улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийг хариуцсан ажилтанд хүлээлгэн өгнө.

6.2.Хариуцсан ажилтан энэ журмын 6.1-д заасны дагуу хүлээлгэн өгсөн үнэмлэх, тэмдгийг энэ журмын 1.10-т заасан бүртгэлд бүртгэсний дараа тойрох хуудаг гарын үсэг зурна.

6.3.Энэ журмын 6.1-д заасны дагуу хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийг хүлээлгэн өгөөгүй тохиолдолд мөн журмын 4.1-д заасан албан тушаалтан холбогдох албан тушаалтанд мэдэгдэх, цагдаагийн байгууллагад хандаж шуурхай шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

6.4.Хяналтын улсын байцаагч үнэмлэх, тэмдгээ бусдад шилжүүлсэн, ашиглуулсан, барьцаалсан, үрэгдүүлсэн, гэмтээсэн, хууль бусаар хийлгэсэн, хэлбэр, загварыг өөрчилсөн, хувилсан, өөр зориулалтаар ашигласан бол томилох эрх бүхий албан тушаалтан сахилгын шийтгэл ногдуулна.

6.5.Хариуцсан ажилтан, хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийн хэрэглээ, хадгалалтад хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтан энэ журмыг зөрчсөн нь түүнд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

6.6.Энэ журмыг зөрчсөн этгээдийн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжтэй бол холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлж шалгуулна.

“Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг олгох,
хэрэглэх, түүнд хяналт тавих журам”-ын
1 дүгээр хавсралт

АЛБАНЫ ДУГААР

№	БАЙГУУЛЛАГЫН НЭР	КОД
Нэг.Төрийн захиргааны төв байгууллага		
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	01
2	Барилга, хот байгуулалтын яам	02
3	Боловсрол, шинжлэх ухааны яам	03
4	Зам, тээврийн хөгжлийн яам	04
5	Соёлын яам	05
6	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	06
7	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	07
8	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	08
9	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	09
10	Эрүүл мэндийн яам	10
11	Эрчим хүчний яам	11
12	Стандарт, хэмжил зүйн газар	12
Хоёр.Нийслэл, аймаг		
1	Нийслэл	13
2	Архангай аймаг	14
3	Баян-Өлгий аймаг	15
4	Баянхонгор аймаг	16
5	Булган аймаг	17
6	Говь-Алтай	18
7	Говьсүмбэр аймаг	19
8	Дархан-Уул аймаг	20
9	Дорноговь аймаг	21
10	Дорнод аймаг	22
11	Дундговь аймаг	23
12	Завхан аймаг	24
13	Орхон аймаг	25
14	Өвөрхангай аймаг	26
15	Өмнөговь аймаг	27
16	Сүхбаатар аймаг	28
17	Сэлэнгэ аймаг	29
18	Төв аймаг	30
19	Увс аймаг	31
20	Ховд аймаг	32
21	Хөвсгөл аймаг	33
22	Хэнтий аймаг	34

“Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг олгох,
хэрэглэх, түүнд хяналт тавих журам”-ын
2 дугаар хавсралт

ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ТЭМДГИЙН
БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ХҮСНЭГТ

20... оны ... сарын ...-ны өдөр

.....
/Харьяалах байгууллагын нэр/

№	Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр	Албан тушаал	Хяналтын улсын байцаагчийн албаны, салбарын хяналтын чиглэлийн болон хувийн дугаар	Тэмдгийн дардас	Олгосон он, сар, өдөр	Тайлбар

Бүртгэлийг баталгаажуулсан:

Дарга
/Гарын үсэг/

.....
/Гарын үсгийн тайлал/

Бүртгэлийг нэгтгэсэн:

.....
/Албан тушаал/

.....
/Гарын үсэг/

.....
/Гарын үсгийн тайлал/

Жич: “Албан тушаал” гэсэн нүдэнд тухайн хяналтын улсын байцаагчийн албан тушаалыг тодорхой бичнэ. (Жишээ нь: Байгаль орчин, аялал жуулчлалын яамны байгаль орчны хяналтын улсын байцаагч, Архангай аймгийн ... байгаль орчны хяналтын улсын байцаагч гэх мэт.)